

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2018 ОНЫ ЭХНИЙ  
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН

БАРУУН-УРТ ХОТ

2018 ОН

## ГАРЧИГ

1. Өмнөх үг.....	1
2. Удирдлага зохион байгуулалт .....	2
3. Санхүүгийн тайлангийн аудит .....	3
4. Гүйцэтгэлийн аудит .....	4
5. Дотоод ажил .....	5
6. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл .....	6
7. Дүгнэлт, санал.....	7

## ӨМНӨХ ҮГ

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг толилуулж байна.

Байгууллагын эрхэм зорилго, дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэхийн тулд аудитын тайланг чанаржуулах, улс, орон нутагт тулгамдаж буй олон нийтийн анхааралд байгаа, үнэн зөв хариу хүссэн асуудал буюу аудит хийх сэдвийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсрууллаа.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь аудитын үр дүнд эерэг нөлөө үзүүллээ. Мөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан нь үр дүнтэй болсон.

Гүйцэтгэсэн аудит бүрээс шалгагдагч байгууллага өгөөж хүртсэн, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг барагдуулж байгаа нь Төрийн аудитын байгууллагын эрх, үүрэг бүрэн хэрэгжиж буйг илтгэсэн нэг илэрхийлэл боллоо.

Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тодорхой ажлууд хийж, СТАУС программд санхүүгийн тайлангийн аудитын ажлын баримт, тайланг оруулж, мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд дотоод сургалтыг зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.

Манай хамт олон Монгол Улсын Ерөнхий аудиторын дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэхийн төлөө хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, хариуцлагыг сайжруулах замаар аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэн ажиллаа.

*Хүндэтгэсэн*

*Дарга, тэргүүлэх аудитор*

*М.Нарантуяа*

## Нэг. Удирдлага зохион байгуулалт

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар 2018 онд “Төрөлжсөн аудитын чанар, үр дүн, үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудитыг Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомж, аудитын олон улсын стандарт, заавар журам, гарын авлага, аудитын төлөвлөгөө хөтөлбөр, арга зүйн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүллээ. Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүйн шинэчлэлтэй холбоотой хуулийн болон заавар журмын төслүүдэд ажил хэрэгч санал гарган, төрөлжсөн аудитын газруудад хүргүүлсэн бөгөөд манай байгууллагын саналаас тодорхой саналууд тусгагдсан нь үр дүнгээ өгсөн зүйл болжээ.

Манай байгууллага 2017 оны ажил үйлсээрээ аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудыг манлайлан ажиллаж 2-р байр эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.

Байгууллагын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө”-ний дагуу төлөвлөсөн аудит, дотоод ажил, аудитын дэмжих үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлэв. Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар нь дарга, тэргүүлэх аудитор-1, аудитын менежер-1, ахлах аудитор-3, аудитор-6, жолооч-1, үйлчлэгч-1, гэрээт ажилтан-1 нийт 14 орон тоотой үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн. МУЕА-ын 2017 оны 5 сарын 12 өдрийн А/87 тоот тушаалаар батлагдсан ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсан чиг үүрэг, тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангасан аудиторууд ажиллаж байна. Оны эхэнд нягтлан бодогч, бичиг хэрэг, дотоод ажилтан 1, санхүүгийн аудит хийх гэрээт ажилтан 2-ыг сонгон шалгаруулж Тэргүүлэх аудиторын тушаалаар томилсон. Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитортой аудитын нэгжийн удирдлага, ахлах аудитор, аудиторууд үр дүнгийн гэрээ байгуулж, төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлж, өгсөн зөвлөмжийг шалгагдагч байгууллага таатай хүлээн авч байгаа нь аудитаас үр дүн бий болсныг харуулж байна.

Аудитын газрын ажилтнууд 2018 оны хагас жилд нийт 9,178 хүн/цаг ажилласан. Ажилласан хүн/цагийг үйл ажиллагааны нэр төрлөөр ангилж үзвэл санхүүгийн тайлангийн аудитад 85 хувь, гүйцэтгэлийн аудитад 15 хувь тус тус зарцуулсан байна. Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар хамрагдвал зохих 234 байгууллагын 8 байгууллагад итгэл үзүүлэн, 105 байгууллагыг түүвэрт хамруулж, 120 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, нэгдсэн төлөвлөгөөгөөр 2 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэсэн байна.

Эдгээр аудитыг хийж гүйцэтгэснээр нийт 8,380.0 сая төгрөгийн 389 алдаа, зөрчил илрүүлсэн ба үүнээс 409.2 сая төгрөгийн 56 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,734.4 сая төгрөгийн 74 зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 2,561.3 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулга хийлгэж, алдаа дутагдлыг арилгах 3675,1 сая төгрөгийн 246 зөвлөмж өгсөн. Тайлант хугацаанд 183,5 сая төгрөгийн актыг барагдуулж хэрэгжилт 26 хувь, 1,172.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага биелэж, хэрэгжилт 40 хувь, үр ашиг, арвилан хэмнэлт, үр нөлөө, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх 75 зөвлөмж хэрэгжсэн.

Мөн тайлант онд гүйцэтгэсэн аудитаар 508.9 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, төсвөөс авсан 1 төгрөг тутамд 4 төгрөг 24 мөнгөний үр өгөөж бий болгосон.

Зөрчил гаргасан 24 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 8 албан хаагчид хариуцлага тооцуулсан, 20 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж 17 асуудал бүрэн шийдвэрлэгдсэн 3 асуудал хянагдаж байна. Улс,орон нутгийн төсөвт 2018 оны эхний хагас жилд 97.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

## *Хоёр. Санхүүгийн тайлангийн аудит*

### **2.1 Санхүүгийн тайлангийн аудит**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд нь холбогдох заавар журам, стандарт, гарын авлага, аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, сумдын нэгтгэсэн тайлан 14, Засгийн газрын тусгай сангийн 3, орон нутгийн тусгай зориулалтын сан 69, төсвийн шууд захирагчийн 132, ОНӨААТҮГ-ын 14, ТӨҮГ-ын 1 нийт 234 санхүүгийн тайлан хамрагдав. Дээрх байгууллагуудаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 8 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 105 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, нийт 120 байгууллагад дүгнэлт гаргасан байна. Үүнээс 107 байгууллагад “Зөрчилгүй”, 12 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой аудитын өртөг 64.1 сая төгрөг байна. Мөн түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 7,802 хүн/цаг зарцуулан ажилласан. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,679.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитын явцад 2,561.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 1,040.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 402.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой 234 заалт бүхий 3675,1 сая төгрөгийн зөвлөмж өглөө. Төлбөрийн актын 25 хувь, албан шаардлагын 40 хувь, зөвлөмжийн 22.1 хувь нь хэрэгжсэн байна. Энэ нь зарим акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон хэрэгжих шатандаа байгаатай холбоотой. Мөн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 423.0 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

- Аймгийн ТЕЗ нь албан ёсны баталгаажаагүй тогтоолоор төсвийн орлого, зарлагыг 935.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.
- Аймгийн Засаг дарга 2017 оны төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3, 32 дугаар зүйлийн 32.2.11, 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангаагүй толилуулсан. Мөн АИТХ тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, 33 дугаар зүйлийн 33.2.5 дахь заалтыг баримтлаагүй төсвийг баталсан байна.

- Аймаг, сумдын ТТЗ нар төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Сумдын ТТЗ нар Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2<sup>1</sup>-д заасны дагуу төсвийн тодотгол хийх нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлоогүйгээр 362.6 сая төгрөгийн орлого, зарлагыг тодотгосон нь тус хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна. Мөн тодотгол хийхэд уг хуулийн 67 дугаар зүйлийн 67.2<sup>2</sup>-д заасны дагуу төсвийн танилцуулгыг бүрэн боловсруулж тодруулаагүй, төсвийн иж бүрэн бүрэлдэхүүнийг хангаагүйгээр төсвийг өргөн барьж байна.
- Бүх шатны ТТЗ болон ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээ, зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаар танилцуулга бэлтгэж толилуулаагүй, мөн санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн боловсруулж тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг зөрчжээ.
- Сумдын ЭЭС-ууд хувьд шилжсэн, ХХК нэршлээр улсын бүртгэлд бүртгэгдсэн нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын хавсралт журмын 3.2, 3.3, 3.4, УСНББОУС-6 ийн 39-р заалтад заасны дагуу сумын ТТЗ-ийн эрх мэдэл, хяналтад байх чадамжгүй байгаа бөгөөд дээрх дүнгээр ТЕЗ-ийн нэгтгэл үнэн зөв толилуулагдаагүй байна.
- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийг баталсан боловч тухайн жилд хэрэгжүүлэх аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг баталсан тогтоол шийдвэр нь хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болохыг тогтоосон байна.
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, чанаргүй, дутуу хийсэн, тооцоог бодож баталгаажуулаагүй
- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, анхан шатны баримтгүй зарцуулсан
- Хуурамч баримт бүрдүүлэн төсвийн хөрөнгийг захиран зарцуулж, бодит бус гүйцэтгэл гаргасан
- Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулж, худалдан авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй

Санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг тулган баталгаажуулах захидлыг Татварын хэлтэс, НДХ, Дөрвөлж ОНӨҮГ, Талын гал ХК, Энгүүн тал ХК, ШТСтанцууд, Эрчим хүчний Сүхбаатар салбарт тус тус илгээн хариу авч аудитад ашигласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар аудитын үе шатны ажлыг СТАУС программд бүрэн оруулж, нотлох баримтыг бүрдүүлэн хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэв. Санхүүгийн тайлангийн аудитын журмын 2.4.1-д заасны дагуу 2019 онд санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллага, түүвэрт хамрагдах байгууллага, итгэл үзүүлэх байгууллагын судалгааг гаргаж СУГ-т хүргүүлсэн. Мөн 2019 онд гүйцэтгэх аудитын санд нэмэлт, өөрчлөлт баяжилтыг хийж, баталгаажууллаа. 2018 оны санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэх ХАК-ийг сонгон шалгаруулахад шаардлагатай мэдээлэл, судалгааг боловсруулан, зөвлөх үйлчилгээг

1 Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

2 Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана

сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулж байна. Аудит хийгдэх хуваарийг эцэслэн боловсруулж, тэргүүлэх аудиторын тушаалын төслийг бэлтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу санхүүгийн тайлангийн аудит хийгдэж, дүгнэлт гаргахаар төлөвлөгдсөн байгууллагуудад аудитын төлөвлөлтийн өмнөх, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын маягтуудыг СТАУС программд бүрэн хөтөлж хяналтыг хэрэгжүүлсэн. Санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэх чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатанд байгууллагыг сайтар ойлгох, ярилцлага хэлэлцүүлэг хийх, урьдчилсан дүн шинжилгээнүүдийг боловсруулж, шалгах асуудлын эрсдэл, түүнд тохирсон горим сорилоо тодорхойлж аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловрсруулсан.
- Санхүүгийн тайлангийн аудитын материаллаг байдлыг тоон болон чанарын хувьд АОУС-320-д нийцүүлэн төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцооллыг авч үздэг болсон.
- Санхүүгийн аудитын 3 үе шатны ажлын явцад чанарын хяналтын хуудсыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, үе шат бүрт хяналтыг хийж, эргэцийн хуудсыг хөтөлж хэвшсэн.
- Санхүүгийн тайлангийн аудитын түүвэрийн олонлогийг зөв, тохиромжтой сонгох гэх мэт сургалтууд хийгдсэн. Мөн нэгтгэсэн тайланд олон талт стратегийг хийж, аудитын дүгнэлт хийсэн бөгөөд ТЕЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож, нотлох баримтаар баримтжуулан тайлагнадаг болсон.
- Аудитад хамрагдах данс, түүнд хэрэгжүүлэх горим сорилыг иж бүрэн хийж, аудитын нотлох зүйлс, баримтжуулалтыг цуглуулдаг болсон.
- Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийн маягтыг хөтөлж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, дүн шинжилгээ хийж байна.
- САГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу аудитын ажлын баримт, нотлох зүйлсийг хангалттай, зохистой, илүү гуравдагч түвшинээс баримтжуулах тал дээр анхаарч, хэрэгжүүлж байна.
- Дотоод хяналт болон хяналтын байгууллагаас хийсэн шалгалтын тайлан мэдээ, шийдвэрүүдийг үнэлж, холбогдох маягтын дагуу баримтжуулалт хийгдэж байна.
- СТА-ын явцад тухайн байгууллагын санхүүгийн тайланд залруулга хийлгэж, СТАУС программд баталгаажууллаа.
- Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлийг баримтжуулж, шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, нэгтгэлд тайлагнадаг болсон.
- Аудитаар илэрсэн алдаа зөрчил, горим сорилын бүртгэл, нотлох зүйлс, баримтжуулалт болон аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хэрэгжүүлж байна.
- Аудитын тайланг товч, тодорхой, энгийн ойлгогдохуйц хэлбэрээр тайлагнах, үг үсэг, найруулгын алдаагүй илэрхийлэх, материаллаг зөрчлүүдийг авч үзэх, мөн стандартуудыг баримтлах чиглэл дээр шат шатны хяналтыг хийж, баримтжуулж байна.
- Менежментийн захидлын зөвлөмжийг аудитын дүн дүгнэлттэй уяж, арга зүйн дагуу боловсруулан, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж гарын үсэг зуруулж, хэрэгжих огноог хөтөлж хэвшсэн.

- Аудитын менежер Санхүүгийн тайлангийн аудитын бүхий л үе шатанд шаардлагатай мэдээлэл, арга зүйгээр ханган нийтдээ 3 сургалт 4 үүрэг даалгаварыг нэгдсэн журмаар өгч хэрэгжилтийг зохион байгуулсан.

## **2.2 Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар аймгийн төсвийн нийт орлогыг 51,998.2 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1,232.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 53,230.7 сая төгрөгөөр өөрчлөн баталсан байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар санхүүгийн дэмжлэг 5,086.5 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орлогын шилжүүлэг 4,086.8 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 28,080.7 сая, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 1,016.7 сая, урсгал орлого 10,197.3 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 3,480.2 сая, хөрөнгийн орлого 50.0 сая нийт 51,998.2 сая төгрөгөөр төсвийн орлогыг баталжээ. Харин улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл, төсвийн зарлагын хэмнэлт хийхтэй холбогдуулан 2017 оны төсвийн тухай хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

Хуульд орсон энэхүү өөрчлөлтөөр улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг 51.9 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгийг 2,492.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 853.9 сая төгрөгөөр, ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлогыг 91.6 сая төгрөгөөр, төсөл сангийн орлогыг 1,024.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 7,184.2 сая төгрөгөөр, хүн амын орлогын албан татварын буцаан олголтонд 671.5 сая төгрөг олгохоор тооцож нийт татварын болон татварын бус орлогыг 11,723.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 7,726.8 сая төгрөг төвлөрч орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 107.5 хувийн биелэлттэй гарсан байна. Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээр давсан боловч татварын нэр төрлөөр нь авч үзвэл бууны албан татвар, хог хаягдал үйлчилгээний болон улсын тэмдэгтийн хураамж зэрэг 3 нэр төрлийн татвар, хураамж 80.4 сая төгрөг буюу 1.2-32.4 хувиар тасарсан байна.

Зарим нэр төрлийн орлого тасарсан шалтгааныг авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөөг бууруулсан, өөр аймгийн төсөвт төвлөрүүлсэн, бууны албан татвар төлөгчийн тоо бүртгэл зөрүүтэй байсан зэрэг нь нөлөөлжээ.

Мөнххаан сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого 17.9 сая төгрөгөөр тасарсан байна. Тайлант онд ХХОАТ-ын орлого 3.5 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.8 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 24.6 сая төгрөгөөр, торгуулийн орлого 1.4 сая төгрөгөөр тус тус тасарчээ. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 24.6 сая төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлсөн байна. Төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах талаарх дараах саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн. Үүнд:



Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр ирсэн боловсролын төсөвт албан байгууллагуудын хоол хүнсний зардал 42.3 сая төгрөг, түлш халаалтын зардал 131.0 сая төгрөгөөр хэмнэгдэх боломжтойг аудитаар тогтоосон болно. Уг төсвийн тооцоололтой холбоотой асуудлыг аудитаар баримтжуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт урсгал зардалд 50,965.8 сая төгрөгийг зарцуулжээ. 2017 онд батлагдсан төсөвтэй харьцуулахад 95.7 хувийн гүйцэтгэл гарсан байна.

Нийт гүйцэтгэлийн 71 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 0.4 хувийг татаас, 16.4 хувийг урсгал шилжүүлэг, 10.4 хувийг хөрөнгийн зардал, 1.8 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлд тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг харьцуулалт хийж харуулбал:

/сая төгрөгөөр/

<i>Үзүүлэлт</i>	<i>Өмнөх оны гүйцэтгэл</i>	<i>Төлөв</i>	<i>Гүйц</i>	<i>Зөрүү</i>	<i>Хувь</i>
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>51,839.4</b>	<b>53,230.7</b>	<b>50,965.8</b>	<b>2,264.9</b>	<b>95.4</b>
<b>Урсгал зардлын дүн</b>	42,745.8	45,599.9	44,721.5	878.4	98.1
<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	36,207.7	36,919.5	36,192.0	727.5	98.3
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	50.0	186.4	186.4	0	100
<b>Хөрөнгийн зардал</b>	8,334.0	5,991.4	5,294.9	696.5	88.3
<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>	759.5	1,639.4	949.3	690.0	57.9

Орон нутгийн төсвийн нийт зарлага 50,965.8 сая буюу 95.74 хувийн гүйцэтгэлтэй гарч 2,264.9 сая төгрөгийн зарлага дутуу санхүүжүүлсэн байна. Зарлагын гүйцэтгэл өмнөх оны түвшингээс 873.6 сая төгрөг буюу 10.1 хувиар буурсан байна.

- Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын тухайн жилд зарцуулах төсвийг тодотгон баталсан нь Төсвийн тухай хууль болон МУЗЗНДНТУ тухай хуульд заасны дагуу АИТХ-ын төлөөлөгчдийн 50-иас дээш хувийн санал авсан, албан ёсны хүчин төгөлдөр тогтоол болсон байдаг. Харин 2017 оны 12 сарын 21-ны өдөр төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах төсвийн тодотгол хэлэлцэж баталсан гэх боловч уг тогтоол нь Аймгийн ИТХ-ын тамга, тэмдэг, бусад зүйлсээр албан ёсны болж, баталгаажгаагүй байдаг. Иймд Аймгийн ТЕЗ нь 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 03 тоот тогтоолоор төсвийг захиран зарцуулж,

тайлагнах байтал, албан ёсны баталгаажуулах тогтоолоор төсвийн орлого, зарлагыг 935.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

- Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн төсвийн жил эхлэхэд аймгийн ИТХ-аар төсвөө батлуулаагүй нөхцөл байдал үүссэн. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/26 тоот захирамж гарч, Төсвийн тухай хуулийн 41.4, 41.6 дахь заалтуудыг үндэслэн төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй нөхцөл байдал үүсвэл төсвийн санхүүжилтийн түр горимыг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан боловч Төсвийн тухай хуулийн 41.4.1, 41.4.2 дахь заалтуудыг мөрдөлгүй цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг өмнөх оны түвшинд санхүүжүүлэхийг захирамжилсан нь уг хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн. Манай байгууллагаас дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй байхад 1,169.6 сая төгрөгийн төсвийг 2017 оны 01 дүгээр сард зарцуулж, Төсвийн тухай хуулийг зөрчсөн.
- Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаагүй “Мал хамгаалах сан”, “Байгаль хамгаалах” сангууд нэгтгэгдэж байна. Иймд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5<sup>3</sup>-д заасны дагуу дээрх сангуудыг ТЕЗ-ийн аль нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлж, нэгтгэх шаардлагатай байна. Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаагүй “Мал хамгаалах сан”, “Байгаль хамгаалах” сангууд нэгтгэгдэж байна. Иймд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5<sup>4</sup>-д заасны дагуу дээрх сангуудыг ТЕЗ-ийн аль нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлж, нэгтгэх шаардлагатай байна.
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд 1,600.0 сая төгрөг баталсан. Үүнд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгосон 500.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл батлагдсан байдаг бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.8<sup>5</sup> дахь заалттай нийцээгүй бөгөөд зарлагаар баталсан нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна. Мөн удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, зарлагын ангилалаар нэг бүрчлэн хэлэлцэж батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна. Төсвийн шаардлага, удирдлагын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөтөлбөр, арга хэмжээ бүрээр хэлэлцээгүйгээс төсөвт батлагдаагүй ОНӨҮГ-ын хэвийн үйл ажиллагааг хангах, үнийн зөрүүнээс үүссэн алдагдлыг нөхөхөд 80.0 сая төгрөг, зүүн бүсийн наадмын үйл ажиллагаанд 100.0 сая төгрөгийг зарцуулжээ. Удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр нэг бүрчлэн баталж өгөөгүйгээс нэг удаагийн шинж чанартай дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулал олгох, уралдаан тэмцээний үйл ажиллагаанд зарцуулах гэх мэт Төсвийн тухай хуульд нийцээгүй зарцуулалтыг гаргасан байна.

<sup>3</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

<sup>4</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

<sup>5</sup> төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр

- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийг баталсан боловч тухайн жилд хэрэгжүүлэх аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг баталсан тогтоол шийдвэр нь хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болохыг тогтоосон байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний харьяаны төсвийн захирагч нарын нэмэлт санхүүжилтийн дансаар 2,841.8 сая төгрөгийн орлого орж, 2,514.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 327.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийг сайдын багцаар нь авч үзвэл:

№	Байгууллагын нэр	Нэмэлт санхүүжилтийн орлого	Нэмэлт санхүүжилтийн зарлага	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдэл
1	ЭМЯ	56.6	56.6	
2	БСШУСЯам	217.8	214.5	3.3
3	ХНХЯам	129.0	129.0	
4	БХБС	7.6	7.6	
5	Орон нутаг	2,430.8	2,106.4	324.5
	ДҮН	2,841.8	2,514.1	327.8

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрийг үндэслэн нэмэлт төсвийг хуваарилалтын дагуу зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

№	Нэр төрөл	Дүн
1.	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,242.3
2.	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27.7
3.	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252.6
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	317.0
5	Төсвийн урамшуулал	2.2

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн.

- Аймгийн Засаг дарга 2017 оны төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.6.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.2.11, 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангаагүй толилуулсан, мөн аймгийн ИТХ тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, 33 дугаар зүйлийн 33.2.5 дахь заалтыг баримтлаагүй төсвийг батласан байна.
- Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн төсвийн жил эхлэхэд аймгийн ИТХ-аар төсвөө батлуулаагүй нөхцөл байдал үүссэн. Иймд төсвийн санхүүжилтийн түр горимыг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан боловч Төсвийн тухай хуулийн 41.4.1, 41.4.2 дахь заалтуудыг мөрдөлгүй цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг өмнөх оны түвшинд санхүүжүүлэхийг захирамжилсан нь уг хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн. Манай байгууллагаас дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй байхад 1,169.6 сая төгрөгийн төсвийг 2017 оны 01 дүгээр сард зарцуулж, Төсвийн тухай хуулийг зөрчжээ.

## Гурав. Гүйцэтгэлийн аудит

Тайлант онд нэгдсэн төлөвлөгөөт 1, өөрийн байгууллагын санаачлагаар 1, нийт 2 гүйцэтгэлийн аудит хийж, аудитын өртөгт 19.2 сая төгрөг зарцуулсан байна. Түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 1,376 хүн/цаг зарцууллаа. Аудитаар нийт 700.3 сая төгрөгийн зөрчил илэрсний 6.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоон, 693.5 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, шалгагдагч байгууллага, албан тушаалтанд 12 зөвлөмж өгч ажиллаа. Гүйцэтгэлийн аудитаар тайлант онд 85.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллага хүлээн зөвшөөрсөн байна.

**Тайлант онд гүйцэтгэсэн аудитын талаар товч дурьдвал:**

### **3.1 Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг аудит**

Улсын төсвийн эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын хувьд 10 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжсэн бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтаар 3, харьцуулалтын аргаар 6, нийт 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна.

Улсын төсвийн эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын аудитын нэгдсэн судалгааг маягтын дагуу шалгагдагч байгууллагаар гаргуулан хянаж УАГ-т хүргүүлж ажиллаа.

### **3.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудын аудит**

**ТАХ-ний төлөвлөлт, хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг судлахад: Баруун-Урт сумын спорт цогцолборын барилга:** Уг төсөл арга хэмжээ нь Эрүүл мэндийн яаманд төлөвлөгдөж, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт тус яаманд зарлагдаж гүйцэтгэгчийг сонгосон. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Тендер сонгон шалгаруулалт орон нутагт зохион байгуулагдаагүй.

**Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг БУА-ын явцад үр нөлөөтэй хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь бодитой үнэлж, баталгаажуулсан эсэхийг шалгахад:** **Баруун-Урт сумын спорт цогцолборын барилга:** Захиалагчийн хяналтын гэрээг Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэх тайлбарыг ГХБХБГ-аас ирүүлсэн байна. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг аймгийн ГХБХБХ, зураг төслийн байгууллага болон хөндлөнгийн хяналтыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн ГХБХБГ-ын 2013 оны 1/77 тоот албан бичгээр Соёл, спорт аялал жуучлалын яаманд барилга угсралтын ажлыг түргэвчлүүлэх хүсэлт гаргасан боловч бодитой ажил зохион байгуулж ажиллаагүй нь БУА одоог хүртэл зогссон байгаагаас харагдаж байна. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Захиалагчийн хяналтыг ГХБХБГ, МХГ болон холбогдох бусад газраас хяналт тавьсан байна. Захиалагчийн хяналтаар гарсан алдаа зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн байна. Барилга угсралтын ажлын зураг төсөлд Барилгын хөгжлийн төвөөс магадлал хийж дүгнэлт гаргасан байна.

**Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд талуудын эрх, үүрэг, бүрэн тусгаж хэрэгжүүсэн байдлыг судлахад:** **Баруун-Урт сумын спорт цогцолборын барилга:** Тус барилга угсралтын ажлын гэрээг 2010 оны 08 сарын 11-ний өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Гэрээнд талуудын эрх, үүргийг бүрэн тусгаж баталгаажуулаагүй байна. Мөн 2012 оны 08 сарын 30-ний өдөр төсөл арга хэмжээний дуусгалтын ажилд 249.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгч компани гэрээнд заасан хугацаанд барилга угсралтын ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байхад дахин тендер сонгон шагаруулалтанд оруулж нэмэлт гэрээ байгуулсан нь учир дутагдалтай байгаа бөгөөд дээрх барилга угсралтын ажилд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж үзэх нь зүйтэй байна. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн эрх үүргийн талаар 3 заалт, гүйцэтгэгчийн эрх үүргийн талаар 6 заалт тусгаж баталгаажуулсан боловч гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлж байгаа талаар тодорхой дүгнэлт гаргаагүй байна.

**Гүйцэтгэгч байгууллага БУА-ыг батлагдсан зураг, төсөл, барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг тодруулахад:** **Баруун-Урт сумын спорт цогцолборын барилга:** Уг барилга угсралтын ажлын техникийн нөхцлийг 2009 оны 02 сард холбогдох холбогдох байгууллага албан тушаалтнаас гаргуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2009 оны 57 тоот захирамжаар газар эзэмших эрхийг баталгаажуулсан байна. Тус барилга угсралтын ажил нь барилгын норм, дүрмийн дагуу гүйцэтгээгүй нь ШУТИС-ын профессор Я.Дүнхэржаваар ахлуулсан ажлын хэсгийн хурлийн тэмдэглэл, дүгнэлт зэргээс харагдаж байна. Хурлын тэмдэглэлд каркасны цутгалтын үед технологийн алдаа гаргаж хүйтний улиралд цутгалт хийсэн, вибратор муу тавьсан учир арматурын хамгаалалтын үе ил гарсан зэргийг дурьдсан байна. Мөн ажлын хэсэг барилгын хэв гажилтанд судалгаа хийхэд 3-4-B-Ё болон 2-3-B-C тэнхлэг хоорондын хучилт 4-5 см хотойсон, бүтээцийн бетоны бат бэх шаардлага хангаагүй, 18, 1-6 тэнхлэгийн хоорондох бетоны бат бэх хучилтын арматурын дээд үе үе хүртэл хөлдсөн гэж дүгнэжээ. Ажлын хэсгийн хурлаар дээрх нөхцөл байдалд тулгуурлан:

- 18, 1-6 тэнхлэг хүртэл налуу хучилтыг буулгах,
- консоль дам нурууны хөлдсөн хэсгийг буулгах
- Дам нуруу, хучилтыг хүчитгэх аргачлал боловсруулсны дагуу автор ажлын зураг хийж өгөх шийдвэр гаргасан байна. Барилгын ажлын явцад 2011 оны 7 сарын 1-ний өдрийн зохиогчийн хяналтын дүгнэлтээр гарсан алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлсэн байна.

**Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Газар эзэмших зөвшөөрлийг сумын засаг даргын 2014 оны А/148 тоот захирамжаар олгосон байна. Тус байгууламжийн тендер сонгон шалгаруулалт орон нутагт хийгдээгүйгээс холбогдох баримт бичиг хангалтгүй байгаа бөгөөд техникийн нөхцөл, хэзээ авсан нь тодорхойгүй байна. Аймгийн ГХБХБГ-аас ирсэн албан бичгээс үзэхэд тус байгууламжийн зураг төслийн ажил боловсруулах явцад БХБЯ-аас зурагт өөрчлөлт оруулах санал гаргасан, тухайн жилүүдийн хөрөнгө оруулалт цаг хугацаандаа хийгдээгүй зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзжээ. Одоогоор тус барилга угралтын ажлын бохир усны цэвэрлэх байгууламж, цэвэр усны худаг, даралтат цамхаг болон цэвэр усны шугам сүлжээ, талбайн тохижилтийн ажлууд хийгдээгүй байна. БХБЯ-д бохир усны цэвэрлэх байгууламжийн техникийн нөхцөл эцэслэн шийдэгдээгүй байгаа нь ажил удааширхад нөлөөлж байна.

**Барилга, байгууламжийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдол хэвээр байгаа эсэхийг судлахад: Спорт цогцолбор:** Аймгийн хэмжээнд спортын үйл ажиллагаа явуулж байгаа барилга нь 1980 онд ашиглалтанд орсон боловч одоог хүртэл их засварын ажил хийгдээгүй байна. Тус барилга нь урд, болон зүүн урд талаасаа цууралт үүсч аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 200,, онд цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлтийг гаргасан байна. Гэвч аймгийн аварга шалгаруулах тэмцээн уралдаан болон бусад томоохон арга хэмжээг зохион байгуулах спорт ордон байхгүйгээс цууралт өгсөн хэсэгт бэхэлгээ хийж одоог хүртэл ашиглаж байна. Мөн аймгийн биеийн тамир спортын газрын дарга, албан хаагчдадтай одоо ашиглагдаж байгаа барилгын талаар уулзалт хийхэд дулаан алдалт ихтэйгээс өвлийн цагт ажил явуулахад хүндрэлтэй, зарим төрлийн спортын секц, дугуйланг явуулах боломжгүй гэсэн тайлбар гаргаж байна. Иймээс шинээр спортын ордонтой аймгийн хэмжээний болон улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн уралдааныг зохион байгуулж, спортын олон төрөл хөгжих ач холбогдолтой байна. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Уг байгууламжийн барилга угсралтын ажил хийгдэж дууссанаар сумын төвийн төсөвт байгууллага нэгдсэн халаалтын системт холбогдогдох, цаашид аж, ахуйн нэгж байгууллага болон айл өрхийг нэгдсэн системд холбуулах ач холбогдолтой байна.

**Дутуу орхигдсон барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх замаар цаашид ашиглах боломжтой эсэхийг судлахад: Спорт цогцолбор:** Гүйцэтгэгч Лайткапитал хаус ХХК-аар гарсан алдаа зөрчлийг арилгуулж барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлж цаашид спорт цогцолбор хэлбэрээр ашиглах боломжтой эсэх талаар тодруулж үзэхэд АЗДТГ-ын барилга хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн дээрх барилгын ашиглах боломжтой гэж үзсэн байна. Гэвч одоогийн байдлаар аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тус барилга угсралтын ажлыг дуусгаж “Хүний хөгжлийн төв” болгохоор БСШУСЯ-нд эрх шилжүүлэн авах тухай 2018 оны 1/658 тоот албан бичгээр хүргүүлээд байна. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн тохижилт”:** Уг байгууламжийн барилга угсралтын ажлыг дуусгахаар улсын төсөвт 608.6 сая төгрөг батлагдаж 2018 оны 04 сарын 10-ний өдөр хугацаа сунгах гэрээ байгуулан ажиллаж байна.

**Барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагагүй барилга, байгууламжийн уяруулсан хохирлыг бодитой тогтоож, хариуцлага тооцсон эсэхийг тодруулахад: Спорт цогцолбор:** Аймгийн ХОХБТХ-ээс барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Лайткапитал хаус ХХК-аар зөрчил дутагдлыг арилгуулах, барилга угсралтын ажлыг дуусгах зорилгоор холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа боловч дээрх компани нь улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх хаяг дээр байхгүй байгаа тул хүндрэл үүссэн байна. Иймд дээрх ЭМЯ болон холбогдох байгууллагатай хамтран Лайткапитал хаус ХХК-ний хаягыг тодруулж хууль хяналтын байгууллагад шилжүүлж улсыг хохиролгүй болгож, барилга угсралтын ажлыг дуусгах шаардлагатай байна. **Эрдэнэцагаан сумын “Сумын төвийн**

**тохижилт”:** Уг барилга угсралтын ажилд төрийн аудитын байгууллагаас хяналт, шалгалт хийж ажлыг түргэвчлүүлэх, захиалагчийн хяналтыг эрчимжүүлэх албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан.

Энэ аудитаар ач холбогдол бүхий голлох асуудлаар судалгаа шинжилгээ хийж илтгэх хуудас хүргүүлсэн болно.

### **3.3 Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 2017 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үр нөлөөт байдал**

Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 2017 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үр нөлөөт байдалд хийсэн аудитыг дараах зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн.

- Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр дүн
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн
- Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны үр дүн

Дэвшүүлсэн зорилго зорилтын хүрээнд нийт 241,5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 227,4 сая төгрөг буюу 94,5 хувийг бүртгэл тайлагналтай холбоотой, хууль эрх зүйн акт зөрчсөн 7,2 сая төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлсэн. Мөн үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд урамшуулал олгосон 6,9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарсан алдаа зөрчилд үндэслэн “Тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлийг бууруулах талаар бодитой ажил зохион байгуулаагүй, тасгийн эрхлэгч өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, эрүүл мэндийн боловсролыг иргэдэд хүргэж байгаа боловч үр дүнг тооцож хэвшээгүй байна” гэсэн дүгнэлт гаргаж зөвлөмж өгсөн.

Удирдлага зохион байгуулалттай холбоотой: Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө гарган ажиллаж байгаа боловч ихэнх ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж дундажаас доогуур, ёс зүйн зөрчил гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажиллаж байна гэсэн дүгнэлт гаргаж зөвлөмж хүргүүллээ.

“Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 2017 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үр байдал”- д гүйцэтгэлийн аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн“ ажлын гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа төлөвлөөгүй нь үр дүнд нөлөөлж байна” гэсэн дүгнэлт өгсөн. Аудитаар илрүүлсэн анхаарал татахуйц асуудлуудаас товч дурдвал:

- Төсвийн төслийг хөтөлбөр арга хэмжээ бүрээр төлөвлөж байгаа боловч зарим зардлыг хууль эрх зүйн актанд үндэслэн боловсруулаагүй.
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.
- Ажилчин албан хаагчидтай холбоотой үүссэн өрийг санхүүгийн тайланд толилуулаагүй.
- Зөвлөлийн бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тооллогын комисс хөрөнгийг үнэн зөв, чанартай, үр дүнтэй зохион байгуулаагүй байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах боловсон хүчин дутмагаас тендерийг хуулийн хүрээнд явуулаагүй.
- Нярайн эндэгдэл өмнөх оноос өссөн байна.
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын үр дүнг тооцож, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй.

- Томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлтийн үед тендерийн эмийн нийлүүлэлтийн хүрэлцээ хангамж дутагдалтай байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар В, С вирусын шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагджээ
- Тасгууд үйл ажиллагааны тайлангаа харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлан бичиж хэвшээгүй байна.
- Тасгийн эрхлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.
- Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 90.2 хувиар хангасан.
- Зарим албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод ажлын чиг үүргийн давхардал гарч байна.
- Нийт бүртгэгдсэн өргөдлийн 34.9 хувь буюу 72 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна
- Иргэдээс бичгээр болон амаар ирсэн санал гомдолд үндэслэн ёс зүйн алдаа гаргасан эмч, эмнэлгийн ажилтанд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Уг аудитаар 693.5 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах 5 албан шаардлага хүргүүлж, 6.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоон, арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, бүртгэл тайлагнал, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, дотоод хяналтыг сайжруулах 12 зөвлөмж өглөө. Аудитаар 1,376 хүн/цаг ажиллаж, аудитын өртөг 7.6 сая төгрөг байна.

### 3.4 “Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн "Засаг дарга данс"-ны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл үр дүн”

Гүйцэтгэлийг авч үзэхэд урсгал зардлаар батлагдсан 81.7 сая төгрөгийн төсвийг хөрөнгийн зардалд, хөрөнгийн зардлаар батлагдсан 346.4 сая төгрөгийн төсвийг урсгал зардалд тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ дахь заалтыг зөрчжээ. Иймд урсгал зардлаар батлагдсан төсвөөс хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх, хөрөнгийн зардлаар батлагдсан төсвөөс урсгал зардалд зарцуулж буй дээрх зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч Төсвийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай.

Урсгал болон хөрөнгийн зардалд батлагдсан төсвөөс санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлбэл зохих эх үүсвэрээр нь ангиллаа. Үүнд:

- ЗДНС-ийн хөрөнгөөр санхүүжүүлбэл зохих төсөл арга хэмжээ: Гадаад дотоодын зочид, төлөөлөгч, төрийн өндөр албан тушаалтныг хүлээн авах, хүндэтгэлийн зардал, багш, сурагч, тамирчид уралдаан тэмцээнд оролцоход олгосон дэмжлэг, шагнал, салбарын болон байгууллагын ойн арга хэмжээнд олгосон дэмжлэг гэх мэт **122.2** сая төгрөгийн зардал.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлбэл зохих төсөл, арга хэмжээ: Наадмын зардалд 100.0 сая төгрөг зарцуулсан, Дөрвөлж ОНӨААТҮГ-т олгосон хэрэглээний халуун усны татаас **236.6** сая төгрөг. Эдгээр төрлийн зардлыг аймгийн 2018 оны төсөвт ОНХС-аар хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулж баталсан байна.
- Хөрөнгө оруулалтын бүс шинжтэй Хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал: Мөрийн хөтөлбөр болон бусад салбарын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой чуулга уулзалт, зөвлөгөөн, сургалт, лекц, туршлага



судлах, аян, өдөрлөг, хууль сурталчлах гэх мэт арга хэмжээний **144.9** сая төгрөгийн зардал.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлбэл зохих төсөл арга хэмжээ: Төсвийн байгууллага болон ОНӨААТҮГ-уудын их засвар, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг шинэчлэх зэрэг материаллаг баазыг бэхжүүлэх болон ЖДҮ-ийг дэмжих сангийн зээл /500 сая төг/ олгоход чиглэсэн **791.1** сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлууд.

“Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ”, “Боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн бусад салбарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан 144.9 сая төгрөгийн урсгал зардалтай адил төрлийн зардлуудыг цаашид “*Хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал*”-д нэгтгэн төсөвлөх шаардлагатай. Харин **ЗДНС /122.2 сая төгрөг/** болон **ОНХС-/236.6 сая төгрөг/-**гийн хөрөнгөөр санхүүжүүлбэл зохих урсгал зардал/*нийт 358.8 сая төгрөг/*-ыг энэхүү зориулалт, арга хэмжээний төсөвт тусгахгүй байх. “*Хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал*”-ыг төсөвлөхдөө төсөл, арга хэмжээ бүрийг жагсаалтаар гаргаж<sup>6</sup> батлуулах шаардлагатай.

Тайланд онд бусад зориулалт, арга хэмжээний зардлын хувьд 7 нэр төрлийн ажил гүйлгээг санхүүжүүлжээ. Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох буцалтгүй тусламжийн санхүүжилт 205.2 сая төгрөг, өвс тэжээлийн нөөцийн санхүүжилт 207.6 сая төгрөг, нийт 412.8 сая төгрөгийн санхүүжилт тайлант оны эцэст орж ирсэн бөгөөд уг дүнгээр төсөвт тодотгол хийж, батлагдаагүй нь аймгийн ИТХ хуралдаагүйтэй холбоотой<sup>7</sup> байна. Төсвийн тухай хуулийн 58.2.10 дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр усан хангамжийн татаасыг санхүүжүүлэх боломжтой байхад орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлаар баталж санхүүжүүлсэн алдаа, зөрчил илэрсэн. Харин аймгийн 2018 оны төсвийн төсөл боловсруулахдаа уг зөрчлийг арилгаж, “усны татаас”-ыг ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулж 77.2 сая төгрөг батлагджээ.

Дунд хугацааны бодлогын баримт бичиг болон хөтөлбөрүүдийн зарим зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Зөөлөн дэд бүтэц”-д хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх”, “Боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн бусад салбарын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх” зардлуудын хувьд нийт 466.5 сая төгрөгийн зардлын гүйцэтгэл гарсан ба үүнээс урсгал зардалд 266.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 199.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин “Зөөлөн дэд бүтцийг” бий болгоход чиглэсэн төсөл, арга хэмжээ санхүүжүүлээгүй байна.

---

<sup>6</sup> МУЗГ-ын 2014 оны 147 тоот “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 3.6, 3.7, 4 дэх заалтуудыг шалгуур үзүүлэлт болгох.

<sup>7</sup> Энэ талаар Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн “Зөөлөн дэд бүтэц”<sup>8</sup>-д хөрөнгө оруулалт хийх боломжтой зорилт, арга хэмжээнүүдийг дараах байдлаар ангиллаа. Үүнд:

- **Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:** “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Сүхбаатар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр”, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Сүхбаатар аймгийн дэд хөтөлбөр”-үүдэд *“халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “өвчлөлийн үр дагаварыг эрт сээрэмжлүүлэх”* болон *“иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг, мэдээллийг сайжруулах”* талаар нийт 14 зорилт, арга хэмжээ,
- **Ерөнхий боловсролын чиглэлээр:** “Сүхбаатар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр”, “Сүхбаатар аймгийн Боловсролын хөгжлийн хөгжлийн хөтөлбөр”-үүдэд *“боловсролын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх”* болон *“сурагчдын бие даан суралцах чадварыг хөгжүүлэх”* талаар нийт 7 зорилт, арга хэмжээ,
- **Хууль эрх зүйн чиглэлээр:** “Сүхбаатар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр”-т *“төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах”, “иргэдэд эрх зүйн мэдлэг олгох үйл ажиллагаа зохион байгуулах”, “хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааны нэр төрлийг нэмэгдүүлж, хамрагдалтын түвшинг дээшлүүлэх”, “хуулийн хэрэгжилтийг сайжруулах”* талаар 7 дэд зорилт, 20 арга хэмжээ,
- **Цахим засаглалын чиглэлээр:** “Сүхбаатар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр”-т *“Цахим засаглалыг нэвтрүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийн ил тод, байдлыг хангах” “төрийн байгууллагын удирдлага мэдээллийн цахим системийг нэвтрүүлэх”, “иргэдийн оролцоог хангах, санал хүсэлтээ илэрхийлэх, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх, хариу өгөх цахим үйлчилгээг бий болгох”* талаар 1 дэд зорилт, 2 арга хэмжээ тус тус тусгагджээ.

Иймд аймаг, орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэнд, боловсрол болон хууль эрх зүйн салбарын хувьд зөөлөн дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой дараах төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- **“Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн цахим хуудас ажиллуулах төсөл арга хэмжээ”** нь дараах давуу талтай.
  - Цахим хуудаснаас эрүүл мэндийн мэдлэг, мэдээлэл авч буй иргэдийн хандалтын тоог гарган, үнэлж дүгнэх боломжтой болно,
  - Ямар төрлийн мэдлэг, мэдээлэл жилийн аль цаг үед эрэлт хэрэгцээтэй байгааг тодорхойлж, шинжлэх нөхцөл бүрдэнэ,
  - Эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдээллийг оновчтой, шуурхай байршуулах зэрэг нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.

---

<sup>8</sup> “Зөөлөн дэд бүтэц” гэж боловсрол, соёл, эрүүл мэнд болон бусад салбарын мэдлэг, мэдээллийг иргэдэд хүртээмжтэй олгох боломжтой цахим хуудас, /вэб сайт/, програм хангамж, оюуны өмчийн зөрчилгүй цахим хичээл, хууль, эрх зүйн түгээмэл асуулт, хариултын цахим сан гэх мэт зүйлсийг хамруулан ойлгоно.

- “ЕБС-ийн математик, хими, физикийн сурах бичгийн<sup>9</sup> бодлогууд болон шалгалтын материалын бодолтыг нэгдсэн цахим хуудсанд байршуулах төсөл арга хэмжээ” нь дараах давуу талтай.
  - Эцэг эхийн зүгээс хүүхэддээ тусалж, дэмжихэд нийцсэн цахим гарын авлага бий болж, боловсролын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ,
  - Сурагч өөрөө суралцах, хоцрогдлоо арилгахад туслах цахим орчин бий болж, сурлагын чанар дээшилнэ,
  - Бие даан суралцах чадвартай иргэн болж төлөвших үндэс суурь тавигдаж, боловсрол олгох үйл ажиллагааны үр нөлөө дээшилнэ.
- “Хууль эрх зүйн зохицуулалтыг практик жишээгээр тайлбарласан, асуулт, хариулт бүхий нэгдсэн цахим хуудас ажиллуулах төсөл арга хэмжээ” нь дараах давуу талтай.
  - Хууль тогтоомжийн заалтыг бодит, практик жишээгээр тайлбарлан, асуулт-хариулт хэлбэрээр байршуулах нь иргэд, олон нийтэд ойлгомжтой болно,
  - Иргэд, олон нийт болон төрийн албан хаагч нар хууль тогтоомжийн заалт, зохицуулалтын талаар нэг ойлголттой болох,
  - Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааны уламжлалт арга хандлагатай харьцуулахад иргэд, олон нийтэд илүү хүртээмжтэй.

Нийгмийн эрүүл мэнд, боловсрол болон хууль эрх зүйн салбаруудад санал болгосон болон тэдгээртэй адилтгах зөөлөн дэд бүтэц бий болгоход чиглэсэн төсөл, арга хэмжээнүүдэд орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй. Учир нь “Зөөлөн дэд бүтэц” нь ихэвчлэн програм хангамж /вэб болон бусад төрлийн/ хэлбэртэй байдаг бөгөөд сургалт, сурталчилгаа болон боловсрол олгох үйл ажиллагааны уламжлалт арга хандлагатай хослуулан ашиглах нь тухайн зорилт, арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй. Иймд эдгээр төрлийн төсөл, арга хэмжээг<sup>10</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой<sup>11</sup> тул “ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт<sup>12</sup>, төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тусгаж, төсөвлөх талаар зөвлөмж хүргүүллээ.

### **Ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал:**

Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 сарын 27-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын дэргэд “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан” байгуулж, мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 82 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам” батлагдсан. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасан “*Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл*”-ийг “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ нь одоогийн байдлаар аваагүй байгаа бөгөөд тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай 6 нэр төрлийн баримт

<sup>9</sup> Зохиогчийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.4, 16.1-д заасны дагуу зохиогчийн эрхийн зөвшөөрлийг авсан байх.

<sup>10</sup> Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу тухайн төсөл, арга хэмжээ нь төсөвт өртгийн тооцоо, судалгаатай байх.

<sup>11</sup> Энэ төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь ОНХС-ийн заавартай нийцэж байна.

<sup>12</sup> Төсвийн тухай хуульд “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ гэж заасан. Өмчлөлд шилжих хөрөнгө гэдэгт биет хөрөнгө болон биет бус хөрөнгийг хамруулан ойлгоно.

бичгийг боловсруулж, бүртгүүлэх шатандаа байна. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж үзээд тус журам нь захиргааны хэм хэмжээний актын хувьд холбогдох хууль зүйн шаардлагыг хангахгүй байгаа тул зөрчлийг арилгаж дахин ирүүлэхийг хариу мэдэгдэж, тус журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй захиргааны хэм хэмжээний акт */Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам/-*ыг үндэслэн “Ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал”-аас 500 сая төгрөгийг “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын дэргэдэх “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-д шилжүүлж, тус сангаас ЖДҮ-ийн зээл олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т */Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ./* гэж заасныг зөрчсөн байна. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн яам дахин хянаад, тус “захиргааны хэм хэмжээний акт”-ыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх хүртэлх хугацаанд ЖДҮ-ийг дэмжих орон нутгийн тусгай сангаас зээл олгохгүй байх талаар албан шаардлага хүргүүллээ. Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн Засаг даргын орлогч нарт нэг удаагийн тэтгэмжид нийт 17.3 сая төгрөгийн олгосон нь холбогдох хуулийг зөрчжээ.

#### **Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, тэтгэлгийн зардал:**

Тайлант онд дараах хууль тогтоомжуудыг үндэслэн 10 төрийн албан хаагчид нийт 131.7 сая төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолыг үндэслэн 4 албан хаагч */төрийн жинхэнэ албан хаагч/-*д 73.1 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж,
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2<sup>13</sup> дахь заалтыг үндэслэн 3 албан хаагч */улс төрийн албан хаагч/-*д 41.0 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тусламж,
- Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>14</sup> дэх заалтыг үндэслэн 3 албан хаагч */төрийн үйлчилгээний албан хаагч/-*д 17.6 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Хөдөлмөрийн тухай хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 42 дугаар зүйлд “Төсвийн байгууллагаас энэ хуулийн 42.1-д заасан нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан нийтлэг журмыг Засгийн газар батална.” гэсэн заалтыг нэмсэн байна. Харин Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д Засгийн газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн 338 дугаар тогтоолоор

<sup>13</sup> 38.2.Төрийн албанд 25-аас дээш жил ажилласан аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга тэтгэвэр тогтоолгох бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 12 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.

<sup>14</sup> 42.1.Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

нэмэлт өөрчлөлт оруулахдаа зөвхөн эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээний ажилтнуудад хамаарах заалтыг нэмсэн. Өөрөөр хэлбэл эрүүл мэнд, боловсролын салбараас бусад төсвийн байгууллагаас тэтгэвэрт гарч буй төрийн үйлчилгээний албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох тухай заалт, зохицуулалт одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид байхгүй. Эндээс үзэхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн 17.6 сая төгрөгийг төрийн үйлчилгээний 3 албан хаагчид олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна. Иймд дээрх харилцааг хууль тогтоомжоор зөвшөөрөх хүртэл хугацаанд энэхүү зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ. Харин холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг эрх бүхий дээд шатны байгууллагад хүргүүлэхийг зөвлөмж болголоо. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолыг үндэслэн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо захирамжид олговол зохих дүнгээс 1.0 сая төгрөгөөр илүү тусгаж, тухайн төрийн албан хаагчийн дансанд шилжүүлсэн зөрчил илэрсэн тул төлбөрийн акт тогтоолоо.

### **Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговорын зардал:**

Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч гэсэн албан тушаалд ажиллаж байсан нийт 55 албан хаагчид 205.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон байна. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.” гэж заасан. Эндээс үзвэл сумдын Засаг даргын орлогч сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгохооргүй байна. Иймд 5 сумын Засаг даргын орлогчид нийт 17.3 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон нь хууль тогтоомж зөрчсөн тул энэхүү зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

1. “Зөөлөн дэд бүтэц”-ийг сургалт, сурталчилгаа болон боловсрол олгох үйл ажиллагааны уламжлалт арга хандлагатай хослуулан ашиглах нь тухайн зорилт, арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлдэг тул дунд хугацааны бодлогын баримт бичиг болон хөтөлбөрүүдийн зарим зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах “Зөөлөн дэд бүтэц”-д хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Энэ төрлийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой байна.
2. Урсгал зардлаар батлагдсан төсвөөс 81.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, хөрөнгийн зардлаар батлагдсан төсвөөс 346.4 сая төгрөгийг урсгал зардалд тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 */батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/* дахь заалтыг зөрчсөн байна.
3. “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал” болон “Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлсэн 791.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй адил төрлийн төсөл, арга хэмжээг цаашид “*Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээ*”-ний жагсаалтад нэгтгэн төсөвлөх шаардлагатай байна.

4. “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ”, “Боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн бусад салбарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан 144.9 сая төгрөгийн урсгал зардалтай адил төрлийн зардлуудыг цаашид “*Хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал*”<sup>15</sup>-д нэгтгэн төсөвлөх шаардлагатай байна.
5. Харин ЗДНС болон ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлбэл зохих урсгал зардлыг “*Хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал*”-ын төсөвт тусгахгүй байх, харин энэхүү зардлыг төсөвлөхдөө төсөл, арга хэмжээ бүрийг жагсаалтаар гаргаж төсөвт тусгах шаардлагатай.

Хүргүүлсэн зөвлөмж:

1. Мөрийн хөтөлбөр болон салбар салбарын бодлогын баримт бичгүүдийн хувьд “Зөөлөн дэд бүтэц” шаардлагатай зорилт, арга хэмжээнд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй. Харин эдгээр төрлийн төсөл, арга хэмжээг<sup>16</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой бөгөөд ОНХС-ийн заавартай нийцэж байгаа тул цаашид “ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт”<sup>17</sup>, төсөл, арга хэмжээний жагсаалт”-д оруулж, төсөвт тусгуулах.
2. “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал” болон “Боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн бусад салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал”-аас урьдчилан тооцох боломжгүй, цаг үеийн шинжтэй урсгал зардлуудыг санхүүжүүлж байгаа зөрчлийг зогсоож, энэ төрлийн урсгал зардлыг ЗДНС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх.
  - а. Цаашид энэ төрлийн зардлыг ЗДНС-аас санхүүжүүлэхдээ МУЗГ-ын 2014 оны 147 тоот “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 3.6, 3.7, 4 дэх заалтуудыг шалгуур үзүүлэлт болгох, улмаар хууль тогтоомжийн шалгуурт нийцсэн зардлуудыг чухлаас нь чухал бус хүртэл эрэмбэлсэний үндсэн дээр ЗДНС-ийн нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг үндэслэн санхүүжүүлэх.
  - б. ЗДНС-ийн нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг үндэслэн санхүүжүүлэх боломжтой зардлуудыг нэр төрлөөр нь ангилж, төрөл тус бүрт зарцуулах зарлагын хязгаарыг дотоод хяналтын зорилгоор төсвийн жилийн эхэнд тодорхойлох.
3. Урсгал зардлаар батлагдсан төсвөөс хөрөнгийн зардалд, хөрөнгийн зардлаар батлагдсан төсвөөс урсгал зардалд зарцуулахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

---

<sup>15</sup> Энэхүү зардлыг “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал” нэртэй зориулалт арга хэмжээнд төсөвлөх нь оновчтой.

<sup>16</sup> Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу тухайн төсөл, арга хэмжээ нь төсөвт өртгийн тооцоо, судалгаатай байх.

<sup>17</sup> Төсвийн тухай хуульд “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ гэж заасан. Өмчлөлд шилжих хөрөнгө гэдэгт биет хөрөнгө болон биет бус хөрөнгийг хамруулан ойлгоно.

Эрүүл мэнд, боловсролын салбараас бусад төсвийн байгууллагаас тэтгэвэрт гарч буй төрийн үйлчилгээний албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгохтой холбоотой заалт, зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгуулах тухай саналыг эрх бүхий дээд шатны байгууллагад уламжлахыг зөвлөсөн. Гүйцэтгэлийн аудитыг чанартай гүйцэтгэх чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан, аудитын стандарт, арга зүйг хангаж ажиллаа. Хийгдсэн ажлуудыг товч дурдвал:

- Аудитын багийн гишүүдийн ажлыг асуудал тус бүрээр авч үзэн, аудит хийх түршлага дээр тулгуурлан аудиторчуудын үр чадаврыг үнэлж, баримтжуулан хийгдэх ажлуудыг хуваарилж хэвшсэн.
- Байгууллагын гадаад, дотоод орчин, хууль эрх зүй, бодлого чиглэлийг судлан аудитын эрсдлийг тогтоож, нөхцөл байдал хүндрэл бэрхшээлийн дүн шинжилгээ хийлгэн шалгах асуудлыг тодорхойлдог болсон.
- Мөн шалгах асуудалтай холбогдуулан шалгуурыг үнэн зөв үнэлж тогтоох чиглэлээр аудиторчуудад 2 удаагийн сургалтыг аудитын менежер зохион байгуулсан. Аудитын үе шатны нотлох зүйл, баримтжуулалтыг 3 үе шат тус бүрд бүрдүүлж хэвшиж байна.
- Аудитын материаллаг байдлыг тооцож, материаллаг байдлаас давсан зөрчил, дутагдлыг аудитаар тайлагнах, мөн аудитын эрсдэл арга зүйтэй холбогдуулан аудитын материаллаг байдлыг авч үзэж байна.
- Нэгдсэн удирдамжаар хийж байгаа аудитчуудыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловрсуулдаг болсон.
- Аудитын төлөвлөлтийн үе шатад аудитын үр өгөөжийг тооцоолж, төлөвлөж байна. Мөн аудитын менежер аудитын үр өгөөж, түүнийг сайжруулах арга замууд сэдэвт сургалтыг бүх аудиторчуудад өгсөн байна.
- Аудитын асуудлыг дэмжих, дүгнэлт хийхэд зохистой, хангалттай, хүчин төгөлдөр нотлох баримтыг бүрдүүлэх чиглэлээр аудитын багийн бүрэлдэхүүн ажилладаг болсон.
- Цуглуулсан нотлох зүйлийг үнэлж, материаллаг байдлын тооцооллыг харгалзан үзэж дүгнэлтэнд нөлөөлүүлэхийг хянан удирдах ажилтан зөвлөсөн бөгөөд аудитын баг хэрэгжүүлэн ажилласан байна.
- Аудитын дүн дүгнэлтийг зорилго, зорилттойгоо уялдуулан өгсөн
- Аудитын тайланг утга найруулгын хувьд тохиромжтой илэрхийлж, аудитын илрүүлэлт үр дагавартай нь холбогдуулан аудитын зөвлөмжийг өгсөн.
- Аудитын чанарын хяналтаар өгсөн зөвлөмж, чиглэлийг заавал эцэслэн шийдвэрлүүлж, нотлох баримтаар баримтжуулж байна. Мөн ГА, НА-ын журам, Аудитын чанарын хяналтын журмын дагуу аудитын хяналтын эргэцийн хүснэгт, хяналтын маягтуудыг бүрэн хөтлөгдөж хэвшсэн.

## *Дөрөв. Дотоод ажил*

### 4.1 Байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаар:

- Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар 2018 онд гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг [www.audit.mn](http://www.audit.mn) веб сайтад бүрэн байршуулж, олон нийтэд цахимаар түгээлээ.

- Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж, аудитыг стандарт, журам, гарын авлагын дагуу гүйцэтгэлээ.
- Аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч, холбогдох тайланг хуульд заасны дагуу 02 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт хүргүүллээ.
- Төрийн албан хаагчдын “Бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г цахим сайтад хугацаанд нь шивж оруулсан.
- Аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хэрэгжүүлж, холбогдох маягтыг хөтөлж, баталгаажуулан, заавар зөвлөгөө өгч ажиллаа. Мөн Аудитыг төлөвлөгөө хөтөлбөр, арга зүйн дагуу үр дүнтэй гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавих, стандарт заавар журам хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийсэн.
- Аудитор, шинжээч нар төлөвлөсөн ажлаа хэрхэн үр дүнтэй гүйцэтгэж байгаад тухай бүр харилцан санал солилцох, үүрэг чиглэл өгөх, Тэргүүлэх аудиторт танилцуулж шийдвэрлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.
- Үндэсний аудитын газраас ирүүлсэн 13 судалгаа, санал асуулга, Эрсдлийн, Санхүү, Нийцлийн аудитын, Аудитын сэдвийг сонгох, төлөвлөх, бүртгэх, тайлагнах гэх мэт холбогдох журмын төслүүдэд хэлэлцүүлэг хийн саналыг нэгтгэн дүгнэж Стратеги удирдлагын газар болон төрөлжсөн газар, албадуудад хүргүүллээ.
- Төрийн Аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, семинар, зөвлөгөөнд тэргүүлэх аудитор М.Нарантуяа, менежерүүдийн сургалтанд аудитын менежер Г.Даваа, Сангийн яамнаас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам” сэдэвт сургалтанд ахлах аудитор Г.Оюунболд, С.Ариунбаяр, МЕРИТ төслөөс зохион байгуулсан Чадавхийг бэхжүүлэх сургалтанд 4 аудитор, Төрийн нууцын сургалтанд 9 аудитор тус тус оролцлоо.
- Аймгийн Тэргүүлэх аудиторын баталсан 2018 онд хэрэгжүүлэх МТС –ын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дотоод сургалтыг амжилттай зохион байгууллаа. Уг сургалтаар ажлын байран дээрх сургалт 4 сэдвээр хийж давхардсан тоогоор 11 аудитор хамрагдав.
- Аймаг, орон нутагт аудитын иргэний бүлгийг ажиллуулахтай холбогдуулан 2019 онд шаардах төсвийн тооцооллыг боловсруулж, хүргүүллээ.
- Хагас жилийн байдлаар Үндэсний аудитын газраас 93, Санхүүгийн тайлангийн аудит хийлгэхтэй холбоотой 172, Акт, албан шаардлагын биелэлтийг хүргүүлсэн 32, бусад албан байгууллагаас 108 албан тоот нийт 405 ирсэн бичиг, Санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтийн гэрчилгээ 120, Үндэсний аудитын газар болон бусад албан байгууллага руу 107 албан бичиг болон хугацаатай судалгаануудыг цаг тухайд нь гарган хүргүүлж нийт 227 бичиг явсан байна.



#### 4.2 Байгууллагын болон санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар:

- ТШЗ нарын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын дүнг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, дээд шатны төсөв захирагчид, ТТЗ, нягтлан бодогчид, сумдын санхүүгийн албаны дарга нарт танилцуулсан.
- ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төлөвлөгөөгөөр хийгдсэн аудитын дүнг шалгагдагч байгууллагад нь танилцуулан, хэлэлцүүлэг хийж, үр дүнг тооцож ажиллаа.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгат гүйцэтгэлийн аудитуудыг хугацаанд гүйцэтгэж Тэргүүлэгчдийн болон Төлөөлөгчдийн хуралд танилцуулсан.
- Мэдээллийн ил тод байдлыг хангаж төсвийн гүйцэтгэлийн мэдээг ханын самбарт мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг shilendans.gov.mn сайтад сар бүр цаг хугацаанд нь байршуулж ажилласан.
- Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18,6-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний орлогоос аудит хийхэд гарсан зардал, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай төсөв хуваарилуулахаар аймгийн ИТХ болон СТСХэлтэст хүсэлт гаргасан. Мөн аудитын үйлчилгээний орлогоос нэмэлтээр төсөв батлагдсан тохиолдолд зарцуулах эрх авах хүсэлтийг ЯАГ-ын Тамгын газар, Ажлын албанд хүргүүлж МУЕА-ын 2018 оны 5-р сарын 31-ний өдрийн А/134 тоот тушаалаар 23,1 сая төгрөгийн нэмэлт орлогыг зарцуулах эрх олгосон.

#### 4.3 Бусад ажлын талаар:

- ЯАГ-аас зохион байгуулсан онлайн хурлуудад тоног төхөөрөмж, сүлжээний бэлэн байдлыг хангаж, оролцсон.
- Чанарын баталгаажуулалтын албаны шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, удирдамж боловсруулан ажиллаж хэрэгжилт, үр дүнг хагас жилийн байдлаар гарган хүргүүлээ.
- Аудитын зөвлөмж, акт албан шаардлагыг барагдуулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлж байна. Тухайлбал: Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хууль хяналтын байгууллага руу шилжүүлж байна. Мөн он дамжсан хугацаа хэтэрсэн актуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн 15 асуудлын 631,8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, баталгаажуулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн. Өмнөх оны албан шаардлагын үлдэгдлээс 248,1 сая төгрөгийн зөрчил бүрэн хэрэгжсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.
- Аймгийн хэмжээнд зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээ, мод тарих, арчилах, шувууны үүр хийх, суурилуулах ажил болон кросс гүйлтийн арга хэмжээнд хамт олноороо идэвхитэй оролцов.

- Хамт олны хурлын шийдвэрээр аудиторуудыг төрийн болон салбар, яамдын шагналд тодорхойлж, аудитор А.Мөнхцэцэг “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнагдав.

## Тав. Санхүүгийн тайлагнал, Төсвийн гүйцэтгэл

Санхүүгийн тайланг УСНББОУС, НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад заавар журамд заасны дагуу цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнан ҮАГ-т хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал 2017 оны санхүүгийн тайланг 2018 онд Улаанбаатар аудит корпораци ХХК-иар аудитлуулсан бөгөөд "Зөрчилгүй санал" дүгнэлт авч ажиллаа. Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг хийж гүйцэтгэхдээ Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажилласан. Түүнчлэн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн бусад мэдээ мэдээллийг "Мэдээллийн ил тод байдлын самбар"-т тухай бүр байршуулахын зэрэгцээ шилэн дансны нэгдсэн портал сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан.

Батлагдсан төсөв 125.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 119.9 сая төгрөг зарцуулж 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Батлагдсан төсөвт багтаан өр, авлага үүсгэлгүй ажиллаж байна. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны дотор дээд шатны байгууллагад хүргүүлнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай тогтоол гарч, дүнг баталгаажуулж ажилласан.

6

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу 2018 онд санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан болон хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйн улмаас гүйцэтгэлийн аудитаар материаллаг хэмжээний зөрчил гаргасан 24 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэнээс 8 албан хаагчид хариуцлага тооцсон тухай албан бичиг ирүүлсэн бөгөөд хариуцлага тооцох 16 албан шаардлагын хугацаа нь болоогүй байна.

Аудитаар нийт 508.9сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, төсвөөс авсан санхүүжилтийн нэг төгрөг тутамд 4 төгрөг 24 мөнгөний үр өгөөжийг бий болгосон үр дүнтэй байна. Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-ний дагуу тухайн жилд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлыг аудитын арга зүй, стандарт, аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хугацаанд чанартай гүйцэтгэв.

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа АДБОУС, Аудитын Олон улсын стандартыг мөрдөн, Төрийн аудитын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх,

шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байх үндсэн зарчмуудыг баримтлан, ёс зүйн хэм хэмжээг сахиж, сонирхлын зөрчилгүй хамт олноороо ажиллаа.

**Санал:**

- Аудиторуудыг хөгжүүлэх цаг хугацаа, Давтан аудит хийх асуудлыг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгайлан авч үзэх шаардлага үүсч байна.
- ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа “Эргэлтийн эмийн сан”-уудын асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**М.НАРАНТУЯА**